



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

# **“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

## 1. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

### Хүний нөөцийн чиглэлээр:

**Цаг ашиглалт:** “Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай” хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2022 оны 05 сарын 01-ны өдрөөс эхлэн ажилтнуудын биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-өөр цаг бүртгэл хийдэг төхөөрөмжийг сольж, тусгай зориулалтын карт, царайгаар таних төхөөрөмжөөр тоноглон ирц бүртгэлийг ажлыг гүйцэтгэж байна. Мөн Угтах үйлчилгээний ажилтан гадуур ажлын бүртгэлийн дэвтрийг хөтлөн, ирсэн, явсан цагийг ажилтны гарын үсгээр баталгаажуулан авч бүртгэж байна. Ирцийн тайланг тухайн сар бүр 2 удаа гаргаж, цагийн бүртгэлтэй тулгалт хийн, Санхүү, эдийн засгийн газарт хүргүүлж байна.

**Компанийн хөдөлмөрийн харилцааг удирдан зохион байгуулах ажлын хүрээнд:** 2022 оны жилийн 4 дүгээр улирлын байдлаар хөдөлмөрийн харилцаатай холбоотой 785 тушаалын төсөл боловсруулан албажуулсан. Үүнд:

- Ажилд томилох тухай – 215
- Түр томилох тухай – 184
- Шилжүүлэн томилох тухай – 54
- Ажлаас халах тухай – 13
- Сахилгын шийтгэл ногдуулах тухай - 38
- Ажлаас чөлөөлөх тухай – 113
- Тусламж, дэмжлэг үзүүлэх тухай – 33
- Чөлөө олгох тухай – 43
- Ээлжийн амралтаас дуудан ажиллуулах тухай – 13
- Жирэмсний амралт олгох тухай – 5
- Бусад – 74

Мөн ажилтнаас ирүүлсэн 236 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлүүлэн, холбогдох дүрэм, журмын дагуу зохих арга хэмжээг авч ажилласан.

### Сонгон шалгаруулалт:

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар үндсэн хөдөлмөрийн гэрээт 406 ажилтан ажиллаж байгаагаас төв ажлын байранд 135, “Төмөртэй өртөө”-нд 66, Цогтцэций өртөөнд 164, ТЗЗБМА 41, мөн хөлсөөр ажиллуулах гэрээт 117 нийт 523 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Сул ажлын байранд ажил горилогчийн сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, компанийн “Ажилтан сонгон шалгаруулах журам”-ын дагуу нээлттэйгээр зохион байгуулж, нээлттэй ажлын байрны зарыг компанийн [www.mtz.mn](http://www.mtz.mn) сайт, нийгмийн сүлжээний хэрэгслүүд болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан байршуулан ажилласан.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслийн хүрээнд Өмнөговь аймгийн Манлай, Цогтцэций, Дорноговь аймгийн Мандах, Сайншанд сумдын болон бусад аймаг орон нутгаас 87 иргэдийг ажлын байраар ханган ажиллаж байна. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416,1 км зам дээр туршилт, зүгшрүүлэлтийн тээвэр явуулахтай холбоотойгоор шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний нарийвчилсэн тоон үзүүлэлтийг гарган, шалгаруулалтыг богино хугацаанд амжилттай зохион байгуулж ажилласан. Мөн Өмнөговь аймагт байрлах “Дабльфиш” ХХК-ний дэргэдэх Төмөр замын мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, сургуулийн оюутаныг төмөр замын бүтээн байгуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд танилцах болон үйлдвэрлэлийн дадлага хийлгэх, шилдэг суралцагсдыг ажлын байраар хангах ажлыг үе шаттай зохион байгууллаа. Цаашлаад сум, орон нутгийн иргэдэд төмөр замын мэргэжлийн боловсрол олгох, ажлын байраар хангах бодлого баримтлан ажиллаж байна.

Төмөр замын мэргэжлийн болон техникийн боловсролтой ажилтнуудыг Төмөр замын дээд сургуультай хамтран боловсролын түвшин ахиулах, мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулж ажиллаж байгаа бөгөөд дээд боловсрол /бакалаврын зэрэгтэй/ эзэмшихээр 4, техникийн боловсрол эзэмшихээр 6 ажилтныг тус сургуулиас зохион байгуулж байгаа эчнээ болон зайн сургалтад /онлайн/ хамруулаад байна.

### Автомашин ашиглалт

Монголын төмөр зам ТӨХК нь суудлийн 2 автомашиныг Улаанбаатар хот доторх үйлчилгээнд, туулах чадвар сайтай автомашин-5, бага оврын хүн тээврийн автобус-3 хөдөө орон нутагт байрлах өртөө, зөрлөгүүдийн үйлчилгээнд ажиллуулж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 449-р тогтоолын дагуу 09-45 УНУ улсын дугаартай “Тоёота ланд круйзер 200” маркийн автомашиныг Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлэн өгсөн.

### Архив, албан хэрэг хөтлөлт

Байгууллагын архивын нийт 2399 хадгаламжийн нэгжийг цаг тухайд нь компанийн зохион байгуулалтын нэгж болон аудитын байгууллагын ажиллагсад, давхардсан тоогоор 306 хүнд танилцуулж, хуулбар, лавлагаа олгож мэдээ, мэдээллээр хангаж ирлээ.

Хадгаламжийн нэгжид бүрдүүлэлт, тавигдах шаардлага сэдвээр 4 удаа үзүүлэх сургалтыг зохион байгуулж, арга зүй, заавар, зөвлөмжөөр хангаж ажиллав.

Архивт хадгалагдаж байгаа байнга хадгалах 2008-2021 оны удирдлагын баримтыг 100% цахим хэлбэрт шилжүүлж ашиглалтын болон хамгаалалтын цахим хувь үйлдэж, архивын цахим мэдээллийн сан үүсгэн эх баримтыг бүрэн бүтэн хадгалж, архивын үйлчилгээг цахимаар хүлээн авч шийдвэрлэх, ажлыг хийж гүйцэтгэсэн.

Архивын тухай Монгол улсын хуулийг шинэчилж, 2020.04.24-ны өдрийн МУ-ын УИХ-ын чуулганаар хэлэлцэн архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Байгууллагын дэргэдэх баримт нягтлан шалгах комиссын дүрэм, “МТЗ” ТӨХК-ийн архивын үйл ажиллагааны журам боловсруулсан.

Архивын үйл ажиллагааны нөхцөл байдал, эрсдэл, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн нийцэл, үйл ажиллагааны процесс зэргийг тодорхойлж “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Чанарын менежментийн тогтолцоо-Архив Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны стандарт, ISO9001:2015 хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын архивт 2021 оны 533 хадгаламжийн нэгжээр нөхөн бүрдүүлэлтээр баяжилт хийгдснийг доорх хүснэгтээр харуулбал:

№	Газар	Он, цаг	Бүртгэлийн нэгжийн нэр	Дүн, тоо
1	Удирдлагын баримт	2021	Байнга хадгалах хадгаламжийн нэгж	36
		2021	70 жил хадгалах хадгаламжийн нэгж	27
		2021	Түр хадгалах хадгаламжийн нэгж	226
2	Төслийн баримт	2021	Байнга хадгалах хадгаламжийн нэгж	244
		2021	CD жагсаалт	6

### Мэдээлэл технологи:

“Докс” и-оффис систем:

Байгууллагын дотоод хэрэгцээнд зориулж веб-д суурилсан “Докс” и-оффис системийг тогтмол хөгжүүлж байна. Энэхүү систем нь хүний нөөц, цаг бүртгэл, албан бичиг, тушаал, архив, хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл, шуурхай хурал, төлөвлөгөө биелэлт, гэрээ бүртгэл гэсэн дэд програмуудтай судалгаа, санал асуулга, хэрэгцээт файлууд, зургийн цомог гэсэн дэд модулиудтай ба бүх ажилчид холбогдох боломжтойгоороо давуу талтай юм. Албан бичиг, тушаал, ажлын даалгавар ирэх зэргийг мэдээлэх, хариутай албан бичиг, өргөдөл гомдол, гэрээт ажилчдын гэрээ дуусах хугацаа, зэргийг сануулах функцээр өдөр тутмын ажлыг шуурхай хэрэгжүүлж ажиллаж байна. Хайлт шүүлтийн функцийг бүх дэд програмуудад хийж өгсөн ба мэдээллийг оновчтойгоор хайх, шүүх боломжтой.

Хүний нөөцийн программ нь Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журамд нийцсэн ба мэдээллийг олон төрлөөр бүртгэх боломжтой бөгөөд ажилчид өөрсдийн хөдөлмөрийн харилцааны мэдээлэл болон ирц бүртгэл, ажилласан жил, цаг ашиглалт, олон төрлийн тайланг нэгдсэн форматаар гаргах, төлөвлөх, санал асуулгад оролцох зэрэг шаардлагатай мэдээллийг авах, хянах боломжтой. Мөн графикчилсан мэдээллүүд дээр үндэслэж хүний нөөц бүрдүүлэлтэд дүн шинжилгээ хийх бололцоотой.

Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэлийн программд зүтгүүр болон вагоны ерөнхий мэдээлэл, засвар үйлчилгээтэй холбоотой мэдээллүүдийг бүртгэж байна.

Төлөвлөгөө биелэлтийн программыг хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн ба энэхүү программаар ажилчид 7 хоногийн төлөвлөгөө, биелэлтээ бичиж, газар нэгжүүдийн нэгдсэн тайлан гаргадаг.

Гэрээ бүртгэлийн программ нь гэрээнд оролцогч, хариуцагч нарыг бүртгэж эхлэх дуусах хугацаанд суурилж гэрээг сунгах, цуцлах тухай мэдээлэл өгдөг. Мөн гэрээний явцын дүгнэлт бичих боломжтой. Цаашид гэрээг цахимаар хэлэлцүүлж боловсруулахаар ажиллаж байна.

Норматив үзлэгийн программ нь инженерүүдэд хуваарьлагдсан нормативт ажлуудыг хугацааны давтамжаар сануулах, үзлэгийн биелэлтийг файлаар хавсаргаж тайлагнах үндсэн зорилготой. Энэхүү программын тусламжтайгаар хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтэц, барилга байгууламжтай холбоотой нормативт үзлэгүүдийг хариуцсан инженерүүд цаг тухай бүрт хийж гарч болох эрсдлүүдээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

Тээврийн программ нь Төмөртэй өртөөний ачилтын мэдээллийг нэгтгэж тайлагнах зорилготой. Воганаар тээвэрлэж буй экспортын болон дотоодын ачаа тээврийн мэдээлэл, автомашинаар гаалийн талбайд бууж буй ачааны мэдээлэл дээр үндэслэн захиалгат тээвэр төлөвлөсөн хугацаанд дуусах эсвэл хоцрох зэргийг тооцож анхааруулдаг. Энэ нь ажлын гүйцэтгэлийг хянаж менежмент хийх бололцоогоор хангах давуу талтай юм.

#### **Төслийн удирдлагын “Прайм прожектс” программ:**

Төслийн удирдлагын “Прайм прожектс” программыг хөгжүүлж эхний хувилбарыг хэрэглээнд нэвтрүүлсэн. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416,1 км төмөр замын төслийн газар шороо, гүүр, хоолой, дээд бүтэц угсралт, материал үйлдвэрлэлт, эрчим хүч, барилга, дохиолол холбооны ажлуудын төлөвлөгөө гүйцэтгэлийг уг программаар хянан ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны хэрэгжүүлж буй авто замын төслүүдийг нэгтгэн хянах програмчлалыг хийсэн ба тус яамны серверт программ хангамжийг суурилуулж “Улаанбаатар-Дархан” чиглэлийн авто замын төслийн гүйцэтгэлийг хянаж ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас салбарын мэдээллийг цахимжуулах зорилгоор нэгдсэн платформ хөгжүүлж байгаа бөгөөд тус платформд тус компанийн хөдлөх бүрэлдэхүүн, ачаа тээврийн болон хүний нөөцийн мэдээллийг оруулж, хөгжүүлэлтийг хийж байна.

мэдээллэн ажиллаж байна.

## **ДОТООД АУДИТ**

Дотоод аудитын албанаас 2022 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Компанийн засаглалыг сайжруулах, Компанийн засаглалыг олон улсын түвшинд хүргэх зорилтын хүрээнд: Компанийн үйл ажиллагаанд нэгдсэн менежментийн тогтолцооны олон улсын стандарт /ISO/ нэвтрүүлэх сургалтад хамрагдаж даалгаваруудын дагуу үйл ажиллагааны дараалал sipos, процессын зураглал хийж батлуулсан бөгөөд компанийн хэмжээнд мөрдөж байгаа хуулийн нийцлийг нэгтгэсэн. Аудиторууд сургалтад бүрэн хамрагдаж аудитын чанарын тогтолцооны сертификат гардан авсан.

Үндэсний аудитын газраас Засаглалын аудитыг ЗТХЯ, ТӨБЗГ-т, Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд аудит хийж байгаа тул үйл ажиллагаа, тогтоол шийдвэр, дүрэм, журам, бусад 2019, 2020, 2021 оны шаардсан материал, Төслийн материалуудыг бэлтгэж гарган хамтран ажиллаж байна.

2022 оны 5 сарын байдлаарх компанийн үйл ажиллагаанд Эрсдлийн шинжилгээ хийж Гүйцэтгэх захирал, газрын дарга нар болон ТУЗ-д танилцуулсан. Эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх хорооны бүрэлдэхүүнд аудиторууд орж ажиллан 10 сарын байдлаар эрсдэлд чиглэсэн үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх захирал, ТУЗ-д мөн танилцуулаад байна. ТУЗ-ын Аудитын хороонд дотоод аудитын тайлан, төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр боловсруулж танилцуулсан.

2. Компанийн дотоод зарим ажилчдын ажил үүргийн биелэлт, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд: Ажлын хэсгийн ажил үүргийн биелэлтийн-1, Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийн-2, Гүйцэтгэх захирлын тушаалын хэрэгжилтийн-1 дотоод аудит

хийж тайланг Гүйцэтгэх захиралд танилцуулан зөвлөмж, саналуудыг газар, албадад хүргүүлсэн. Өгөгдсөн зөвлөмжийн дагуух арга хэмжээ бүрэн хэрэгжсэн.

3. Санхүүгийн ил тод байдлыг хангах, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах зорилтын хүрээнд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж сар тутам мэдээллийг тогтмол шилэн дансанд байршуулахад хяналт тавьж, улирал тутам дотоод аудит хийн ажиллаж байна. Шилэн дансны мэдээлэлийг хуулийн хугацаанд хоцроолгүй бүрэн оруулж байна. Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэн ажилласан. ҮАГ-ын аудитын зөвлөмжийн дагуу хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулж Гүйцэтгэх захирлаар батлуулан биелэлтийг хангахад бусад газруудтай хамтран ажиллаж биелэлтийн тайланг ЗТХЯ, ҮАГ-т албан бичгээр хүргүүлсэн. ҮАГ-ын цахим системд аудитын зөвлөмжийн биелэлтийг холбогдох материалуудын хамт байршуулсан.

4. Шилэн дансны хуулийн хэрэгжилт-3 ,Төмөртэй өртөөний үйл ажиллагаа, санхүүгийн эхний хагас жилийн гүйцэтгэл-1, Худалдан авалтын-3, Автомашины түрээсийн гэрээний хэрэгжилтэнд-1, Цагийн бүртгэл, цалингийн тооцоолол-1 удаа тус тус дотоод аудит хийж дүгнэлт, зөвлөмжийг Гүйцэтгэх захирал болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан.

5. Томилолтоор -3 удаа Өмнөговь аймаг руу (Зүүнбаян-Тавантолгой чиглэлд төмөр зам барих төсөл) 2 удаа, Төмөртэй өртөө Сэлэнгэ аймаг руу 2 удаа нийт 4 удаа явж хагас жил, жилийн эцсийн тооллого, үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийсэн ажлын тайланг Гүйцэтгэх захиралд танилцуулсан.

6. СЯ-д цахимаар-4, ЗТХЯ-д албан бичгээр Шилэн дансны тайлан мэдээ-4, аудитын зөвлөмжийн биелэлтийн тайлан-2, ҮАГ-т зөвлөмжийн биелэлтийн тайлан-1, ТӨБЗГ-т ҮАГ-ын зөвлөмжийн дагуу асуудал шийдвэрлүүлэх чиглэл хүссэн албан бичиг – 1ш тус тус явуулсан.

7. Компани 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар нийт 305 гэрээг аж ахуй нэгж, хувь иргэнтэй хуулийн хүрээнд байгуулсан байна. Уг гэрээнүүдийг дугаар өгөн, PDF байдлаар хадгаламжийн нэгж үүсгэн программын бүртгэл оруулан хадгалж байна.

## **ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗАР**

Хууль, эрх зүйн газрын бүтэц, зохион байгуулалтын хувьд 8 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

## **Дотоод үйл ажиллагаа**

Компанийн удирдлага, бусад газар, нэгж, албадыг хууль, эрх зүйн мэдээллээр хангах үйл ажиллагааг өдөр тутам хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн ашиг сонирхлыг зохих байгууллагад төлөөлөх, хууль тогтоомжийн хүрээнд эрх зүйн зөвлөгөө өгөх, тайлбар, дүгнэлт гаргах ажлыг тогтмол гүйцэтгэж байна.

Гүйцэтгэх захирлын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/138 тоот тушаалын дагуу “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх , архидан согтуурахтай тэмцэх тухай сургалт”-ыг зохион байгуулахаар хөтөлбөр боловсруулсан. Сургалтын материал бэлтгэж, орон нутгийн салбар, нэгжид сургалт зохион байгуулсан.

2022 оны 12 дугаар сарын байдлаар компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 45 дүрэм, журам, зааврыг холбогдох газар, нэгжүүдтэй хамтран боловсруулж, хяналт тавьж Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан байна.

2022 оны 12 сарын байдлаар компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 45 дүрэм, журам, зааврыг холбогдох газар, нэгжүүдтэй хамтран боловсруулж, хяналт тавьж Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан байна.

Гүйцэтгэх захирлын 2022 оны А/112 дугаар тушаалаар Ажилтныг сэлгэн ажиллуулах журам, А/133 дугаар тушаалаар Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, А/134 дугаар тушаалаар Албан хэрэг хөтлөлтийн журамд нэмэлт өөрчлөлт оруулсан. “Архивын журам”, “Архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын төслийг хянах ажиллагаа хийгдэж байна.

Мөн Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад саналаа өгсөн.

Гэрээ байгуулахтай холбоотой журмын төслийн эхний хувилбарыг дагалдах зааврын хамт боловсруулж, эцэслэн боловсруулж баталгаажуулахаар хуульч н.Баяраад хүлээлгэн өгсөн.

### **Гэрээ, эрх зүйн нийтлэг асуудлаар:**

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөл болон компанийн бусад дотоод үйл ажиллагаатай холбогдуулан 2022 оны 12 дугаар сарын 07-ны байдлаар дараах төрлөөр нийт 305 гаруй гэрээ байгуулах ажлыг бусад газар, нэгжтэй хамтран зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна. Үүнд: Газар, албадаас боловсруулсан нийт 305 гэрээг хянаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулж, нэгдсэн бүртгэлд хамруулав. Тодруулбал:

1. Түрээсийн гэрээ-87
2. Ажил гүйцэтгэх гэрээ-50
3. Худалдах, худалдан авах гэрээ-54
4. Үйлчилгээ үзүүлэх гэрээ-52
5. Тээврийн гэрээ – 52
6. Бусад-10

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд тус компанийн зүгээс төслийн гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан Ажил гүйцэтгэх гэрээг CD-д хуулбарлан Үндэсний аудитын газар болон МТЗ-д байрлаж ажиллаж байгаа Үндэсний аудитын газрын ажилтнуудад цахим хэлбэрээр хүргүүлсэн.

### **Компанид холбогдох гомдол, маргааны хүрээнд:**

Тайлант хугацаанд компанийн хэмжээнд иргэний- 15, захиргааны- 3, эрүүгийн- 3, нийт 21 хэрэгт шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэнээс 4 хэрэг шийдвэрлэгдсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд 2 иргэний хэрэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж, 1 иргэний хэргийг түдгэлзүүлсэн байна.

### **Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, сургалт явуулах, авлигын эрсдлийг үнэлгээ хийлгэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг тус компанийн 2022 оны хөрөнгө оруулалтын төсөвт тусгуулав.

Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлын эсрэг хязгаарлалт тогтоох, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах Төрийн хэмнэлтийн тухай хууль УИХ-аар баталсантай холбогдуулан МТЗ-ын хүрээнд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээ түүний дотор Авлигын эрсдлийн үнэлгээ хийхэд шаардагдах зардал, төсөв танагдсан болно.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.10.3-т заасан “Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах” зорилтын хүрээнд Авлигатай тэмцэх газраас 2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан “Авлигын шалтгаан нөхцөл, авлигын хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэг, ХАСХОМ-ийг гаргахад анхаарах асуудал” сэдэвт цахим хэлбэрээр сургалтад тус компанийн удирдах болон эрх бүхий албан тушаалтаныг хамруулав.

Авлига, ашиг, сонирхлын зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байнгын сургалт зохион байгуулах талаар “Транспэрэнси интернэшнл-Монгол” ТББ-тай хамтран ажиллах Санамж бичгийг 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан ба санамж бичгийн хүрээнд “Транспэрэнси интернэшнл-монгол” ТББ -тай зохион байгуулах ажлын төлөвлөгөөний төслийг хамтран боловсруулж бэлэн болгосон боловч цар тахлын нөхцөл байдал болон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийг дуусгах ажилтай холбогдуулан хойшлуулсан.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Авлигатай тэмцэх газрын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 03/5221 тоот албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу авлигын эрсдэл, түүний шалтгаан нөхцлийг илрүүлэн тогтоох, арилгах зорилгоор "Онч шийдэл" ТББ тус компанийн хэмжээнд Авлигын эрсдлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан.

Энэхүү ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Гүйцэтгэх захирлын 2022 оны 88 дугаар тушаалаар тус компани Ажлын хэсэг байгуулан хамтран ажиллалаа.

## **Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр**

### **Хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар**

Компанийн бүтэц, зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан тушаалтны нэрсийн жагсаалтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2022 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 01/17 тоот албан бичгээр хүргүүлсэн.

2020 онд шинээр нэмэгдсэн болон хасагдсан мэдүүлэг гаргагч, үүрэгт ажлаас чөлөөлөгдөж шинэчлэн гаргах баталсан жагсаалтаас хасагдаж байгаа албан тушаалтны мэдээлэл, Авлигатай тэмцэх газрын 2021 оны 01/13060 зөвлөмжид заасан мэдүүлэг гаргах тоонд оруулсан “Монголиан порт групп” ХХК-ийн албан тушаалтны мэдээлэл, албан тушаалтны тайлант оны хувийн ашиг сонирхлын хураангуй мэдүүлэг (1 нүүр), хөрөнгө орлогын хураангуй мэдүүлэг (3 нүүр) зэрэг 2021 оны тайлан эцсийн байдлаар 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/295 тоот албан бичгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн.

2022 онд албан тушаалаас чөлөөлөгдсөн 3, халагдсан 1, бусад шалтгаанаар 2, нийт 6 мэдүүлэг гаргах бүртгэлээс хасагдаж, 2021 оны ХАСХОМ-ыг 2022 онд нийт 22 албан тушаалтан хуульд заасан хугацаанд гаргасан.

2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт 9 албан тушаалтан шинээр томилогдож, хуульд заасан хугацаанд ХАСХОМ гаргасан.

### **Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн талаар**

2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт 11 албан тушаалтан Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргаж, АТГ-т хянуулж дүгнэлт гаргуулсан.

### **Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар**

Гэрээ, хэлцэл байгуулах, Ажлын хэсэг, Худалдан авах ажиллагаа, Үнэлгээний хороонд ажиллахын өмнө Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг тухай бүр удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнаас хүлээн авч байна.

2022 онын 12 сарын байдлаар 153 удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл гаргаад байна.

### **Авлигын индексийг бууруулах, зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэх талаар**

АТГ болон “Зөвлөмжийг хэрэгжилтийг хангах тухай” Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03/259 тоотой ирүүлсэн албан бичгийн хариу, холбогдох мэдээллийг 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 102 тоот албан бичгээр хүргүүлэв.

АТГ-аас ирүүлсэн 2022 оны 03 дугаар 18-ны өдрийн 01/3817 тоот албан бичгийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчилд автахаас урьдчилан сэргийлэх “АТГ-Олон нийтийн төв” фэйсбук, пэйж хуудсыг сурталчлах зорилгоор түүнд нэгдэхийг компанийн нийт ажилтан, албан хаагчдад уриалав. Хариу албан бичгийг 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/3817 тоот албан бичгээр хүргүүлэв.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны а/155 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн салбарт Авлигын индексийг бууруулах талаар авах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт”-ийг 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 01/399 тоот албан бичгээр хүргүүлсэн.

## **ТӨСӨЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР**

**Баруун, Зүүн босоо чиглэлийн төмөр замын төслүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдсэн ажлууд:**

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 116 дугаар тогтоолын 1-д заасан “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан” чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих төсөлд хөрөнгө оруулах дотоод, гадаадын аж ахуй нэгжийг сонгох хэлэлцээг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангаж, ЗТХ сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт танилцуулах үүрэг бүхий Дэд ажлын хэсэг гүйцэтгэх захирлын 2022 оны 04-р сарын 11-ний өдрийн А/73 тоот тушаалаар байгуулагдсан. “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан” чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих төсөлд хөрөнгө оруулах дотоод, гадаадын аж ахуй нэгжийг сонгох ажлын хүрээнд хөрөнгө оруулах сонирхол бүхий 26 аж ахуй нэгжтэй уулзаж, санал солилцсон. Урьдчилсан сонголтын шалгуур үзүүлэлтийн баримт бичгийг боловсруулж, УСШҮББ-ийг нийт 36 компанид хүргүүлж, нийт 14 компаниас санал хүлээн авсан. Дэд ажлын хэсэг компаниудын санал тус бүртэй танилцаж, үнэлгээ хийж, ЗТХ-ын Дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэгт тайланг дэлгэрэнгүй байдлаар хүргүүлсэн. Урьдчилсан сонголт цуцлагдсан мэдэгдлийг санал ирүүлсэн 14 компанид албан тоотоор хүргүүлсэн. Гүйцэтгэх захирлын 2022 оны 06-р сарын 07-ны өдрийн А/104 тоот тушаалаар Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан. Урьдчилсан сонголтын шалгуур үзүүлэлтийн баримт бичгийг дахин боловсруулж, урьдчилсан сонголтыг 2022 оны 05-р сарын 17-ны өдөр зарлан, нийт 46 компанид УСШҮББ-ийг хүргүүлж, саналыг 2022 оны 06-р сарын 08-ны өдөр хүлээн авсан. Урьдчилсан сонголтод санал ирүүлсэн компаниудын материалыг УСШҮББ-ийн шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг үнэлж эрэмбэлэн, ЗТХ-ийн Дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэгт хүргүүлсэн. Ажлын хэсэг санхүүгийн чадавхи болон бусад шаардлага хангасан Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төсөлд “Ийст корридор рейлрүүд” ХХК /Консорциум/, “Бодь интернэшнл” ХХК-иудтай, Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын төсөлд “Эссенз Саплайз” ХХК /түншлэл/-тэй хэлцэл хийхийг Дэд ажлын хэсэгт даалгасны дагуу Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлд “Эссенз Саплайз” ХХК /түншлэл/, Чойбалсан-Хөөт, Хөөт-Бичигт чиглэлд “Ийст корридор рейлрүүд” ХХК /түншлэл/, “Бодь интернэшнл” ХХК нартай санал солилцох уулзалтуудыг хийсэн. Дээрх 3 компанитай хийсэн уулзалтын дагуу компани тус бүрийн саналыг бичгээр хүлээн авсан. Зүүн чиглэлийн төсөлд санал ирүүлсэн “Ийст корридор рэйлрүүд” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-ууд нь уг төсөлд хамтран оролцох хүсэлтэй байгаагаа илэрхийлж, хамтарсан хэлбэрээр хэрхэн ажиллах тухай саналаа дахин ирүүлэхээр болсон бөгөөд дээрх 3 компанитай хэлэлцээр хийж, хэлэлцээрийн үр дүнг ЗТХЯ-д танилцуулахаар бэлтгэж байна.

#### **Шивээхүрэн хилийн боомтын төмөр замын төслийн хүрээнд хийгдсэн ажлууд:**

Шивээхүрэн хилийн боомтын төмөр замын асуудлаар БНХАУ-ын “Хөх хотын төмөр зам групп” ХХК-тай цахимаар уулзалт хийсэн. “Хөгжил Шинэтгэлийн Хороо”-той хилийн боомтуудын асуудлаар цахим уулзалт хийсэн. Уулзалтыг Сангийн яамны ТНБД Ж.Ганбат удирдан явуулсан бөгөөд Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замыг эхний ээлжинд нарийн царигаар барьж дараагийн шатанд өргөн царигийн төмөр замаар холбох талаар санал солилцсон. БНХАУ-ын “Хөгжил Шинэтгэлийн Хороо”-оос Шивээхүрэн хилийн боомтын төмөр замын ТЭЗҮ-ийг ирүүлэх хүсэлт гаргасны дагуу “Монголын төмөр зам” ТӨХК боомтын төмөр замын ТЭЗҮС боловсруулж хүргүүлсэн. ТӨБЗГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчийн гэрээ, хөрөнгө оруулагчийн гэрээ гэсэн 3 баримт бичгийн төсөлд “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийн зүгээс саналыг авч эцэслэн боловсруулсан. Шивээхүрэн боомтын өргөн болон нарийн царигийн төмөр замын өртөөдийн баригдах байршлыг тодорхойлж ЗТХЯ-д хүргүүлсэн. Боомтын төмөр замуудтай холбоотой Засгийн газрын тогтоолын төсөл болон танилцуулгыг боловсруулж ЗТХЯ-д хүргүүлсэн.

#### **Тавантолгой-Зүүнбаян төмөр замын төслийн хүрээнд хийгдсэн ажлууд:**

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд хийгдэж байгаа Зөвлөх болон Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийн тайланг хүлээн авч холбогдох Хяналтын багуудаар хянуулж, 55 тайлан хянан баталгаажуулсан тухай акт үйлдсэн. Нийт 43 гүйцэтгэгчээс гүйцэтгэлийн тайлан хүлээлцсэн акт үйлдэн, холбогдох инженерүүдээр хянуулан Маягт №08 үйлдэн баталгаажуулж СЭЗГ-т хүлээлгэн өгсөн.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416,1 км төмөр замын гүйцэтгэлийн тайлангуудын бүрдлийг архивын нэгж болгон бэлтгэн ажиллаж байна. Гүүр, хоолойн барилга угсралтын ажил хийж гүйцэтгэсэн компаниудын тайланг архивын нэгж болгох ажил 85%-ийн гүйцэтгэлтэй байна. Хоолой болон Бетон дэрний тайлангуудыг архивын нэгж болгон 100% хүлээлгэн өгсөн.



- “Солонгосын үндэсний төмөр зам” компанитай 2021 оны 09-р сарын 24-ний өдөр “Тавантолгой-Зүүнбаян” төслийн Дохиолол холбооны системийн зураг төсөл, программ хангамж боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, угсралт суурилуулалтын цогц ажил гүйцэтгэх гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан.

#### **“Монгол - Тяньжины Дунзян тээвэр, логистикийн төв” төсөл:**

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголиа уул уурхайн хөрөнгийн менежмент” ХХК (Хөрөнгө оруулагч тал), “Монголын төмөр зам ТӨХК нь хөрөнгө оруулагч талын 49% хувьцааг гуравдагч талд шилжүүлэх замаар төслийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэхийг харилцан тохиролцсон бөгөөд ЗГ-ын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоол гаргуулах шийдвэрийн дагуу “Монголын төмөр зам” ТӨХК нь 2022.07.06-ны өдрийн 01/1048 тоот төслийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг ТӨБЗГ-т хүргүүлсэн. ТӨБЗГ-аас “Монголиан порт групп” ХХК-ийн үлдэгдэл санхүүжилтийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлэхэд дэмжлэг хүсэх тухай 2022.09.16-ны өдрийн А-1/1795 тоот албан бичгийг МУ-ын Сайд, ЗГХЭГ-ын Дарга Д.Амарбаясгалан-д хүргүүлсэн. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь “Монголиан порт групп” ХХК-ийн төслийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэх боломжгүй тухай 2022.09.30-ны өдрийн ГЁ-117-12/4395 тоот албан бичгийг ТӨБЗГ-т ирүүлээд байна. Одоогоор “Монголиан порт групп” ХХК нь төслийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэж, хамтран ажиллах чадамжтай гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдыг эрэлхийлэн ажиллаж байна. Компанийн үйл ажиллагааны хувьд “Монголиан порт групп” ХХК нь БНХАУ-аас Монгол улс руу контейнер тээврийн зуучлалын үйл ажиллагааг явуулж эхлээд байна.

#### **Замын-Үүдийн Бүс нутгийн ложистикийн төвийг өргөжүүлэн холимог тээврийн терминал байгуулах төслийг хэрэгжүүлэх хүрээнд:**

Замын-Үүдийн Бүс нутгийн ложистикийн төвийг өргөжүүлэн холимог тээврийн терминал байгуулах төслийн хүрээнд “Өвөрмонголын Коско Шиппинг Баотоу ган логистик” ХХК-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Энэхүү санамж бичгийн хүрээнд Бүс нутгийн ложистикийн төвийн өргөтгөл хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг баталсан бөгөөд дараагийн шатны бэлтгэл ажлууд хийгдэж байна.

#### **Төмөр замын салбарын норм нормативын баримт бичгийг боловсруулах зорилтын хүрээнд:**

ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/147 тоот тушаалаар Төмөр замын зам, гүүрийн зураг төсөл боловсруулах үнэ тооцох дүрэм, Төмөр замын дээд бүтэц барих барилгын ажлын төсөв зохиох дүрэм, Төмөр замын барилгын ажлын төсөв зохиох суурь нормуудын төсөлд редакци шүүмж хийлгэх ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг хуралдаж Барилгын төсөвчдийн холбоо болон барилгын зураг төсөл зохиогчдын холбоо, МУ-ын зөвлөх эдийн засагч ,тэргүүлэх төсөвчин С.Нямаагаар хянуулж редакци шүүмж хийлгүүлсэн. Редакци шүүмжийн дагуу төслүүдийг боловсруулж Барилгын эдийн засаг замын төсөв үнэ бүрдлийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар орж, өгсөн үүрэг даалгаврын дагуу боловсруулж Төмөр замын зам, гүүрийн зураг төсөл боловсруулах үнэ тооцох дүрэм, Төмөр замын дээд бүтэц барих барилгын ажлын төсөв зохиох дүрэм, Төмөр замын барилгын ажлын төсөв зохиох суурь нормуудыг 2022 оны 12-р сарын 08-ны өдрийн БХБЯ-ны ШУТТ-ийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж бэлэн болсон.

#### **Бусад хийж хэрэгжүүлсэн ажлууд:**

- Монгол Улсын Засгийн Газрын захиалгаар Монгол Улсын Сангийн яам, Зам тээврийн хөгжлийн яам болон БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яам хооронд байгуулсан Санамж бичгийн хүрээнд “Монгол Улсын төмөр замын хөгжлийн стратеги Зүүн Азийн Төмөр замын нийгэмлэг (ЕАРС)-ийг үүсгэн байгуулалтай уялдах нь” төсөл хэрэгжиж байна. ЗТХЯ-аас уг төслийн монгол талаас хамтран ажиллахыг “Монголын төмөр зам” ТӨХК-д даалгасны дагуу гүйцэтгэх захирлын 2022 оны 03-р сарын 22-ны өдрийн тушаалаар Ажлын хэсэг байгуулж, “Монголын төмөр зам” ТӨХК нь Солонгосын тээврийн судалгааны консорциумтай 2022 оны 04 дугаар сарын 03-ний өдөр ҮҮг-22/160-160/27 дугаартай Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Тус зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу Ажлын хэсэг нь Солонгосын тээвэр судалгааны консорциумд Нарийнсухайт-Тавантолгой, Сайншанд-Хөөт чиглэлүүдийн ТЭЗҮ

боловсруулах судалгааны ажил хийхэд шаардлагатай мэдээллүүдийг гарган өгч хамтран ажиллаж байна.

-“Оросын төмөр замууд” ХНН, “Өвөр монголын Коско шиппинг Баотоу ган ложистик” ХХК, “Солонгосын тээврийн судалгааны консорциум” болон бусад хамтран ажилладаг байгууллагуудтай холбогдолтой албан бичгүүд, шаардлагатай мэдээллүүдийг боловсруулж, орчуулсан.

- “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд зохион байгуулагдаж буй “Тогтвортой хөгжлийн зорилго” нээлттэй өдөрлөгт оролцож, “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын явц, Замын-Үүд-Эрээн хилийн боомт дахь логикийн үйл ажиллагаа мөн шинээр хэрэгжүүлж буй төмөр замын төслүүдийн талаар иргэдэд танилцуулсан.

-“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилт сэдэвт цахим болон 2 өдрийн танхимын сургалтад хамрагдсан.

- “Coal Mongolia-2022” нүүрсний салбарын худалдаа, хөрөнгө оруулалтын Олон Улсын чуулга уулзалт, үзэсгэлэнд байгууллагаа төлөөлөн оролцож илтгэл тавьсан. Илтгэлийн орчуулгыг мөн хийсэн.

-2022 оны 8-р сарын 17-нд “Оросын төмөр замууд” ХН-ийн ерөнхий захирлын 1-р орлогч С.Павлов тэргүүтэй Оросын талын бүрэлдэхүүнтэй хийсэн уулзалтыг зохион байгуулсан. Уулзалттай холбоотой материалуудыг бэлдсэн.

- ЗТХ-ийн Дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэгт ажиллаж Чойлбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж ажлын хэсэгт хүргүүлсэн.

#### **БҮС НУТГИЙН ЛОГИСТИКИЙН ТӨВ:**

2022 оны 02 дугаар сарын .. ны өдөр “Монголын төмөр зам” ТӨХК-ийн бүтцэд шинээр Бүс нутгийн логикийн төвийн нэгж нь 4 хүний бүтэцтэй бий болсон.

Энэхүү “Бүс нутгийн логикийн төв”-ийн үндсэн чиг үүрэг нь “Бүс нутгийн логикийн төв” болон “Шилжүүлэн ачих цогцолбор-1” тус хөрөнгийн ашиглалт, алдагдлыг бууруулах, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, ачаа тээврийн эргэлтийг дэмжсэн хуурай замын хилийн боомтуудын нэвтрүүлэх чадамжийг нэмэгдүүлэх, цаашлаад транзит тээвэр, экспортыг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг хангах, илүү байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник технологи ашигласан бүтээмж өндөртэй тээвэр логикийн төв болгон хөгжүүлэх юм. Үүний хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлж байна. Үүнд:

❖ Дорноговь аймгийн замын-үүд суман дахь бүс нутгийн логикийн төвийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлж буй ажлын хүрээнд:

1. Замын-Үүд-Эрээн хилийн боомтын -0- цэгээр импортын чингэлэг солилцох үйл ажиллагаа:

Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь “Бүс нутгийн логикийн төв”-ийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс Замын-Үүд-Эрээн хилийн боомтод гацсан импортын ачааг хилийн -0- цэгээр оруулж ирэх ажилд оролцох, логикийн төвийн сул байгаа талбайг ашиглах боломж байгаа талаар Боомтын захиргаанд уламжилсан. 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 12 дугаар тогтоолын дагуу “Монголын төмөр зам” ТӨХК Замын-Үүд-Эрээн хилийн боомтын -0- цэгээр орж ирж буй ачааг чингэлэг солилцох байдлаар зохион байгуулахтай холбогдуулан Замын-Үүдийн логикийн талбайг түшиглэн чингэлэг ачиж, буулгах техникийг түрээсийн гэрээ байгуулан, чингэлэг тээврийн ачиж, буулгах үйл ажиллагаа явуулахыг үүрэг болгосон.

Тус тогтоолын дагуу 3 ширхэг чингэлэг ачиж, буулгах техник түрээслэн, мөн өөрийн хөрөнгөөр 1 ширхэг техник худалдан авч, мөн 19 гэрээт хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс хилийн -0- цэгт болон Логистикийн төвд чингэлэг солилцох тээврийн үйл ажиллагаа эхэлсэн.

2022.12.07-ны өдрийн байдлаар

/2022.09.01-2022.09.29/	20 фут чингэлэг	40 фут чингэлэг	нийт чингэлэг
Улсын хилээр нийт орж ирсэн чингэлэг	9727	19097	28824
Улсын хилээр нийт гарсан хоосон чингэлэг	4093	12504	16597

Улсын хилээр нийт гарсан нүүрстэй чингэлэг, /40 футын чингэлгээр бусад түүхий эд/			2735
---	--	--	------

2022 оны 12 дугаар сарын байдлаар Хилийн -0- цэгт болон Логистикийн төвд чингэлэг солилцох тээврийн үйл ажиллагааны хүрээнд 6,728,072,486 төгрөгийн орлого олж, 3,991,955,744 төгрөгийн зардалтай, нийт 2,736,116,742 төгрөгийн ашигтай ажиллаж байна.

2. “Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, Улсын төсвийн Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь “Бүс нутгийн логистикийн төв” болон Япон улсын засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн Замын үүд дэх “Шилжүүлэн ачих цогцолбор-1”-ийн түрээсийн гэрээ, тус хөрөнгийн ашиглалтын өнөөгийн байдал болон тус хөрөнгийн ач холбогдол, ашиг алдагдлын талаар цаашид нэмэгдүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал боловсруулж ТУЗ-д танилцуулсан.

2021 оны санхүүгийн тайлан тэнцэлд Үндэсний Аудитын Газраас хийсэн аудитаар АХБ-ны 35,5 сая ам.доллар болон 3 тэрбум төгрөгийн АХБ-ны зээлээр барьж байгуулагдсан Бүс нутгийн логистикийн төвийг “УБТЗ” ХНН-д алдагдалтай түрээслэж байгааг зөрчил гэж тодорхойлон, засаж залруулах зөвлөмжийг өгсөн.

#### УБТЗ ХНН-тэй байгуулсан түрээсийн гэрээ:

Транзит тээврийн хэмжээ ихэссэн, Логистикийн төвийн ач холбогдол өндөр байгаагаас хамаараад “УБТЗ” ХНН-тэй хийсэн түрээсийн гэрээнд өөрчлөлт оруулах, түрээсийн төлбөрийг нэмэгдүүлэх чиглэлд түрээслэгч талтай хамтран ажиллаж шийдвэрлэхээр саналаа хүргүүлсэн ч хүлээж авах боломжгүй талаар хариу өгсөн.

Бүс нутгийн логистикийн төвийн төслийг төлөвлөгдсөн зориулалт, зорилгод нь нийцүүлэн сул байгаа 270 газарт өргөжүүлэх хөгжүүлэх ажлуудыг үе шаттай үргэлжлүүлэн хийж гүйцэтгэх, энэ ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл хэрэгжүүлэн гүйцэтгэхээр төлөвлөж байна. “Монголын төмөр зам” ТӨХК нь логистик төвийн нөөц боломжид тулгуурлан тодорхой төслүүдийг тухайлбал “Ачиж буулгах терминал”, “AGV – Чингэлэг тээврийн ухаалаг систем”, “Дүүжин тээвэр” гэх мэт төслүүдийг хэрэгжүүлэх боломжийн судалгаа, ТЭЗҮ-г боловсруулахаар БНХАУ-ын далайн тээврийн төрийн өмчит компани болох “Коско шиппинг энд Баоту ган логистик” компанитай санамж бичиг зуран ажлаа эхлүүлсэн. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Замын-Үүдийн логистикийн төвийг ачааны холимог тээврийн терминал, логистикийн үйлчилгээ үзүүлэгч, авто замаас авто зам руу, авто замаас төмөр зам руу болон төмөр замаас авто зам руу ачих ачаа тээврийн боловсруулалт, менежментийг хийж гүйцэтгэх чиг үүрэгтэй “Бүс нутгийн логистикийн төв” болгон өргөжүүлэн, хөгжүүлэх ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг эхлүүлээд байна.


#### ❖ БҮС НУТГИЙН ЛОГИСТИКИЙН ТӨВИЙН ӨРГӨЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

##### ЗГ-н бодлого, шийдвэр:

“Алсын хараа 2050” болон ЗГ-н 2020-2024 хөтөлбөрт “Үндэсний тээвэр логистикийн салбарыг хөгжүүлэх зорилт”, Монгол Улсын Засгийн газрын “ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”– Хилийн боомтуудыг хөгжүүлэх цогц төлөвлөгөөнд үндэслэн Замын-Үүд дахь логистикийн төв цаашлаад хуурай замын хилийн боомтуудын нэвтрүүлэх чадамжийг нэмэгдүүлэх, экспортыг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг хангах, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник технологи ашиглан эрсдэл багатай, бүтээмж өндөртэй олон улсын жишиг логистикийн төв бий болгохоор туссан байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 185 тоот тогтоолын нэгдүгээр хэсэгт коронавируст цар тахлын үед экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор нүүрсний экспорт бүхий хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах, түүний зориулалтаар газар ашиглахыг зөвшөөрөх тухай тусгагдсан нь бидний бүс нутгийн логистикийн төвийг өргөжүүлж, шилжүүлэн ачих терминал байгуулах ерөнхий төлөвлөлт, зорилготой нийцэж байна.

Засгийн газрын 2019 оны 155-р тогтоолоор логистикийн төвийн зориулалтаар 400 га газар олгогдсон. Энэхүү газар нь орон нутгийн газар олголттой давхцалтай тул 2022 оны 08 дугаар сарын 03-ний өдрийн 290 дугаар тогтоолоор газрын солбилцолыг шинэчлэн батлуулсан.



**ГАДААД ХАРИЛЦАА, БИЗНЕС ХӨГЖЛИЙН ГАЗАР:**

**ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ГАЗАР**

**Үйл ажиллагаа:**

“MTЗ” ТӨХК-ийн Тээвэр, логистикийн газар нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Төмөртэй-Хандгайт чиглэлийн 23.4 км замд ачаа илгээгчийн захиалгат ачааны тээвэрлэлтийг зохион байгуулахад нийт 96, Цогтцэций-Зүүнбаян чиглэлийн 416,1 км төмөр замд 243 хүний бүтэц, орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

**Тээвэрлэлт:**

Ачаа урсгалын эрэлтээс шалтгаалан одоогийн байдлаар тээвэрлэлтэд СКD4В маркийн гол замын 5, сэлгээний 1 зүтгүүр, ачилтын 5 зам, 3 талбай, 4 вагон пүү, 1 авто пүү ашиглагдаж байна.

Төмөртэй өртөө нь 2022 оны байдлаар БНХАУ-ын Эрээн өртөөний үйл ажиллагаа цар тахлын дэгдэлт цаашлаад “ДТҮ” ТӨХК-тай холбоотой 11 сарын 14-ний өдрийг хүртэл үйл ажиллагаа түр хязгаарлагдсан байсан ба 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Цогтцэций – Зүүнбаян чиглэлийн төмөр замын Цогтцэций өртөөнөөс 03 дугаар сараас тээвэрлэлт эхэлсэн ба Монгол Улсын Засгийн Газар, ЗТХ-н Сайдын өгсөн чиглэлийн дагуу экспортын нүүрсийг түр хугацаанд хязгаарласан бөгөөд одоогийн байдлаар сайжруулсан шахмал түлшний түүхий /эд мидлинг-г Толгойт өртөө хүртэл өөрийн эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүнээр тээвэрлэж байна.

**Цогтцэций – Зүүнбаян чиглэлийн тээвэрлэлтийн үйл ажиллагаа:**

2022 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн Цогтцэций – Зүүнбаян чиглэлийн төмөр замын Ар-Хонгилдог зөрлөгөөс “Зэсийн баяжмал” ачин туршилтын тээвэр аялаж эхэлсэн бөгөөд 03 дугаар сарын 27-ны өдрөөс Цогтцэций өртөөнөөс “Мидлинг” 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар Цогтцэций-Зүүнбаян чиглэлийн 416,1 км төмөр замд ачаа тээвэрлэх болон эзэмшлийн бус хөдлөх бүрэлдэхүүнийг тээвэрт оролцуулах гэрээ байгуулан нийт 14 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж байна. Бид туршилтын тээврийн хүрээнд нийт 13305 вагон бүхий 690494.14тнн экспортын нүүрс, зэсийн баяжмал, Ханги – Мандал чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой барилгын ачаа, утаагүй түлшний түүхий эд мидлинг зэргийг тээвэрлээд байна.

**Төмөртэй – Хандгайт чиглэлийн тээвэрлэлтийн үйл ажиллагаа:**

Төмөртэй-Хандгайт чиглэлийн 23,4 км төмөр замд нийт 2 аж ахуйн нэгжтэй “төмөр замаар ачаа тээвэрлэх гэрээ” байгуулан ажиллаж байна. Мөн “Төмөр замын зураг төслийн институт” ХХК-тай вагон хадгалалт, таталт тавилт, сэлгээ хийх, тээвэрт бэлдэх тухай гэрээг

байгуулан ажиллаж байна. Төмөртэй өртөөний болон Хандгайт дахь өөрийн эзэмшлийн талбайг “Ганхүдэр орд” ХХК, “Орхон юниверсал” ХХК, “Догшин тайж” ХХК-тай “Төмөртэй өртөөний ачилтын талбайд бараа хадгалах, хадгалуулах гэрээ” байгуулан ажиллаж байна.

2022 оны эхний 3 улирлын байдлаар Төмөртэй өртөөнд галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой осол, гологдол гараагүй, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг бүрэн хангуулан ажилласан.

Цогтцэций-Зүүнбаян чиглэлийн төмөр замын хэмжээнд нийт 2 осол, гологдол гарсныг цаг тухай бүрт холбогдох байгууллагуудтай хамтарч сэргээн босгож, гологдлыг арилгаж ажилласан.

Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн журмын дагуу өвөл зуны Хандгайт-Төмөртэй, Зүүнбаян-Цогтцэций хоорондын замын галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг боловсруулж “ГТХЗНТ” УТҮГ-аар батлуулсан.

Төмөртэй өртөөнөөс 2022 онд 529 вагон 36501 тонн, Цогтцэций өртөө болон Ар хонгилдог зөрлөгөөс 3711 вагон, 235883.5 тонн ачаа ачиж тээвэрлэн, 7051 вагон, 435950.62 тонн ачаа тээвэрлэж буулгасан байна. 2016 оны 05 сарын 13-наас эхлэн 2022 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийг дуустал нийт 101,053 вагон 6,867,578.49 тонн ачаа ачиж тээвэрлэсэн.

2022 онд Төмөртэй болон Хандгайт өртөөний талбайгаас дараах ачаа илгээгч нар ачаа тээвэрлэлтийн гэрээ байгуулан ачилт, буулгалтын үйл ажиллагааг гүйцэтгэсэн. Үүнд:

#### **Төмөртэй өртөө**

Тээвэрлүүлэгч байгууллага	Ачааны нэр	Ачилт		Буулгалт		Нийт	
		Вагон тоо	Жин тонн	Вагон тоо	Жин тонн	Вагон тоо	Жин тонн
“Ган бөмбөлөг ундарга” ХХК	тө/хүдэр	330	22,770			330	22,770
“Дархан Төмөрлөгийн Үйлдвэр” ТӨХК	тө/хүдэр	199	13731			199	13731
“МТЗ” ТӨХК	нүүрс			3	192	3	192
	<b>Бүгд:</b>	<b>529</b>	<b>36,501</b>	<b>3</b>	<b>192</b>	<b>532</b>	<b>36693</b>

Цогтцэций өртөөний ачилтын талбайгаас дараах ачаа илгээгч нар ачаа тээвэрлэлтийн гэрээ байгуулан ачилт, буулгалтын үйл ажиллагааг гүйцэтгэсэн. Үүнд

#### **Цогтцэций өртөө**

Тээвэрлүүлэгч байгууллага	Ачааны нэр	Ачилт		Буулгалт		Нийт	
		Вагон тоо	Жин тонн	Вагон тоо	Жин тонн	Вагон тоо	Жин тонн
“Каус аустралис” ХХК	Нүүрс	800	51018.95			800	51018.95
“Тавантолгой түлш” ХХК	Нүүрс	1513	96359.80			1513	96359.80
“Илинк Жи Ви” ХХК	Нүүрс	600	38054.83			600	38054.83
“Тан Шан Хайган Бао” ХХК	Нүүрс	50	3176.85			50	3176.85
“Вагон Импекс” ХХК	Нүүрс	150	9565.65			150	9585.65
“Хеттрик Ложистик” ХХК	Нүүрс	300	18867.49			300	18872.49
“Плас Эстэймэнт” ХХК	Нүүрс	50	3283.2			50	3283.2
“Оюу толгой” ХХК	Зэсийн баяжмал	100	6481.95			100	6481.95
“Монголиан транс лайн” ХХК	Барилгын материал	44	1304.00	7051	435950.61	7095	437254.61
“МТЗ” ТӨХК	Хоосон			2502	17457.27	2502	17457.27
Олон улсын тээвэр зууч	Хоосон	1	4.8			1	4.8
“Вайрал Инк” ХХК	Нүүрс	198	12299.93			198	12299.93
	<b>Бүгд:</b>	<b>3806</b>	<b>240417.45</b>	<b>9553</b>	<b>453407.88</b>	<b>13359</b>	<b>693850.33</b>

### Ашиглалтын ажлын үзүүлэлтүүд

Д/д	Тээврийн үзүүлэлтүүдийн төрөл	Хэмжих нэгж	2021	2022 он			2022/2021
				төлөвлөгөө	биелэлт	хувь	
1	Хоногийн ажил		59.36	76.56	41.35	54.00	69.65
1.1	Ачилт /вагоноор/	хон.дундаж	59.28	53.41	12.76	23.90	21.53
1.2	Ачилт /тонноор/	тонн	1,336,434.30	1,105,733.80	272,123.50	24.61	20.36
1.3	Ачаатай хүлээн авсан вагон	хон.дундаж	0.09	23.15	28.58	123.47	
1.4	Ачаатай хүлээлгэн өгсөн вагон	хон.дундаж	59.28	53.41	12.76	23.90	21.53
1.5	Буулгалт	хон.дундаж	0.09	23.15	28.58	123.47	
2	Замын хэмжээний ажил	хон.дундаж	59.36	76.56	41.35	54.00	69.65
3	Статик даац	тонн	67.50	61.98	63.83	102.99	94.56
4	Динимик даац /ачаатай вагон/	тонн	67.47	55.91	52.53	93.96	77.86
5	Хоногийн тоо /тайлант хугацаа/	хоног	334.00	334.00	334.00		
6	Тээвэрлэсэн ачааны хэмжээ	тонн	1,337,741.22	1,429,763.80	725,489.59	50.74	54.23
6.1	Оруулалт	тонн	1,306.92	324,030.00	453,366.09	139.91	
	Хандгайтаас /23.4 км/	тонн	1,306.92	370.00	395.00		
	Оруулалт /ЗБ-ХШ/ - 115.1 км	тонн	0.00	313,320.00	435,950.62	139.14	
	Оруулалт /ЗБ-ЦЦ/ - 418.1 км	тонн	0.00	10,340.00	17,020.47	164.61	
6.2	Гаргалт	тонн	1,336,434.30	1,105,733.80	272,123.50	24.61	20.36
6.3	Орон нутаг	тонн	208,786.56	281,328.05	124,809.80	44.36	59.78
	Төмөртэй /23.4 км/		208,786.56	65,520.00	22,858.80	34.89	10.95
	Орон нутаг /115.1 км/	тонн	0.00	1,304.00	1,304.00	100.00	
	Орон нутаг /418.1 км/	тонн	0.00	214,504.05	100,647.00	46.92	
6.4	экспорт	тонн	1,127,647.74	824,405.75	147,313.70	17.87	13.06
	Төмөртэй /23.4 км/		1,127,647.74	690,823.80	13,731.00	0.00	1.22
	экспорт /289.1 км/	тонн	0.00	6,481.95	6,481.95	0.00	
	экспорт /418.1 км/	тонн	0.00	127,100.00	127,100.75	100.00	
7	Ачаа эргэлт	сая тн.км	31,303,144.55	202,942,064.37	155,404,975.61	76.58	496.45
7.1	Оруулалт	--"--	30,581.93	40,394,944.00	57,303,417.87	141.86	
7.2	экспорт	--"--	26,386,957.12	71,179,718.67	55,336,060.72	77.74	209.71
7.3	Орон нутаг	--"--	4,885,605.50	91,367,401.71	42,765,497.02	46.81	875.34
10	Ачааны вагоны ажлын парк	абсолют	27,746.20	32,708.00	15,515.20	47.44	55.92
		хон.дундаж	83.07	97.93	46.45	47.44	55.92
10.1	үүнээс: Хоосон вагон	абсолют	7,977.20	22,600.00	20,799.20	92.03	260.73
		хон.дундаж	23.88	67.66	62.27	92.03	260.73
11	Замын хэмжээний ажил	абсолют	19,827	25,572	13,810	54.00	69.65
12	Ачилт /вагоноор/	--"--	19,798	17,840	4,263	23.90	21.53
13	Ачаатай хүлээн авсан вагон	--"--	29	7,732	9,547	123.47	
14	Ачаатай хүлээлгэн өгсөн вагон	--"--	19,798	17,840	4,263	23.90	21.53
	Төмөртэй /23.4 км/		19,798	12,182	533	0.00	2.69
	БТЕГ -115.1 км		0	44	44	100.00	
	Ар хонгилдог -289.1 км		0	100	100	100.00	
	Цогтцэций -418.1 км		0	5,514	3,586	65.03	
15	Буулгасан вагон тоо	абсолют	29	7,732	9,547	123.47	
	Төмөртэй /23.4 км/		29	10	7	0.00	

	БТЕГ -115.1 км		0	6,055	7,051	116.45	
	Цогтцэций -418.1 км		0	1,667	2,489	149.31	
16	Вагон эргэлт	хоног	1.50	5.60	8.00	142.86	533.33
17	АНАВСЗ	час	10.00	10.00	20.14	201.40	201.40
18	ОНВСЗ	час	15.00	30.00	45.29	150.97	301.93
19	Бохир тонн километр	млн.	52,660,153.30	391,938,733.94	303,907,479.10	77.54	577.11
19.1	Үүнээс: Ачааны хөдөлгөөнд	млн.	52,660,153.30	391,938,733.94	303,907,479.10	77.54	577.11
19.3	аж ахуйн хөдөлгөөнд	--"--	0.00	0.00	0.00		
20	Цэвэр тонн километр	млн.	31,303,144.55	202,942,064.37	155,404,975.61	76.58	496.45
21	Тээвэрлэлтийн дундаж зай		23.40	141.94	214.21	150.91	915.41

Ачилтын төлөвлөгөө			/Цогтцэций/	
Сар	Вагон тоо	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1				
2				
3	157		9621.08	
<b>1-р улирал</b>			<b>9621.08</b>	
4	100	10000	6367.07	63.67
5	50	20000	3172.8	15.86
6	300	20000	19126.45	95.64
<b>2-р улирал</b>		<b>50000</b>	<b>22666.32</b>	45.33
<b>хагас жилээр</b>		<b>50000</b>		64.57
7	350	22260	22225.9	99.85
8	500	22260	31772.64	142.73
9	775	22260	49530.86	
<b>3-р улирал</b>	<b>1625</b>	<b>66780</b>	<b>103529.4</b>	
10	697	84170	43663.96	51.87
11	717	84170	45826.55	54.44
12	<b>76</b>	84170	<b>4883.75</b>	5.8
		<b>252510</b>	<b>94374.26</b>	
<b>Бүтэн жил</b>		<b>369290</b>	<b>236191.06</b>	

2022 онд тээврийн үйл ажиллагаанаас **19,195,950,462.68** төгрөгийн орлого оруулсан байна. Задалж харуулбал:

№	Орлогын нэр	Мөнгөн дүн
1	Тээврийн хөлс	15,521,044,574.78
2	Хоосон тээврийн хөлс	1,762,750,385.95
3	Хоосон чингэлэг тээврийн хөлс	1,113,522,501.95
4	Вагон пүү	79,591,000.00
5	Таталт тавилт	6,028,620.00
6	Дахин сэлгээ	27,355,000.00
7	Зам талбай ашиглалт	429,380,000.00
8	Мэдэгдэл	48,000.00
9	Бичиг баримтны үнэ	246,750.00
10	ЭХТ-н үнэ	11,446.00
11	Калмар	73,513,000.00
12	Кран өргөлт	23,970,000.00
13	Вагон ашиглалт	134,652,000.00
14	Талбайн хадгаламж	98,000.00
15	Резервь гүйлт	989,184.00
16	Вагон хангалт	22,750,000.00
	<b>НИЙТ</b>	<b>19,195,950,462.68</b>

## **Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын үйл ажиллагааны чиглэлээр**

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар зүгшрүүлэх тээврийн үеийн зураг авалт хийгдсэн. Тээврийн үеийн зураг авалтаар билет газарчаар галт тэрэг хүлээн авах, явуулах цаг минутыг тодорхойлон галт тэрэгний хөдөлгөөний зурмагт өртөө зөрлөгт зогсох болон хийгдэх ажиллагааны хугацааг тусгасан.

Нийт мөрдөн ажиллах галт тэрэгний хөдөлгөөн, ачаа тээвэр, техникийн бичиг баримт хөтлөх заавар, вагон жин, техникийн нөхцөл болон тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой техникийн бичиг баримт зэрэг “Тээвэр логистикийн газар”-тай холбоотой 47 ширхэг журмыг боловсруулан батлуулсан. Батлагдсан орон тоогоор шаардлагатай мэргэжлийн боловсон хүчнийг хүний нөөцийн албанаас сонгон шалгаруулж, ажлын байранд нь томилсон. Тус газар удирдлага, зохион байгуулалтаар ханган, заавар зааварчилгаа өгч ажиллаж байна.

Цогтцэций – Зүүнбаян чиглэлийн төмөр замд “УБТЗ” ХНН, “МТЛ” ХХК, “ТТТЗ” ХХК нартай хамтран “Галт тэрэг солилцох нэгдсэн журам” боловсруулан галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажилаж байна.

### **ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ГАЗАР**

#### **Хяналт, шалгалтын чиглэлээр:**

МТЗ” ТӨХК-ийн Хяналт шалгалтын газар нь төмөр замын үндсэн мэргэжил тус бүрээр болон байгаль орчин ХАБЭА чиглэлээр нийт 11 байцаагчийн бүрэлдэхүүнтэйгээр холбогдох дүрэм, журмын хүрээнд ажил үүргээ гүйцэтгэж байна.

ХШГ-ын чиглэл хариуцсан байцаагч нар нь Төмөр замын тээврийн тухай хууль болон Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, түүнтэй нийцүүлэн гаргасан холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу Компанийн суурь бүтэц, зам талбай, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд мэргэжлийн чиглэлээр төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн үзлэг, шалгалтуудыг хийж учирч болзошгүй аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, төмөр замын тээврийн аюулгүй, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангуулах талаар хяналт тавьж ажиллаж байна.

#### **Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:**


ХШГ-ын чиглэл хариуцсан байцаагч анар нь Тавантолгой-Зүүнбаян төмөр замын төслийн хяналтыг 25 удаа, Төмөртэй өртөөний тээврийн аюулгүй байдлын хяналтыг 2 удаа, нийт 27 удаагийн хяналт, шалгалтуудыг хийж гүйцэтгэсэн. Үзлэг шалгалтаар илэрсэн гэмтэл, дутагдалуудыг засаж арилгах талаар холбогдох заавар, зөвлөмжүүдийг өгсөн ба нийт 106 заалт бүхий акт, албан шаардлагуудыг өгч гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан.





## Төмөртэй өртөө

■ Хэдэн удаа ■ Хэд хоног




- 3-р сарын 07-ны өдөр Ар хонгилдог зөрлөгөөс 6001-р галт тэргийг Зүүнбаян зөрлөг хүртэл дагалдаж хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан ба Зүүнбаян өртөөнд галт тэргийг зохих дүрэм журмын дагуу хүлээлгэн өгч хамтарсан акт үйлдсэн.
- Архонгилдог, Баянбулаг, Хунхар заг зөрлөгүүдийн техникийн бичиг баримтын хөтлөлт, зам сумын хамтарсан үзлэгийг хийж илэрсэн гэмтэл, дутагдлуудыг хэрхэн засаж арилгах талаар заавар чиглэл өгч ажилласан.
- “Монголиан Транс Ложистик” ХХК-ийн захиалгийн дагуу Гүйцэтгэх захирлын 01/492 албан тоотод заагдсан комисс Хулангийн шанд-Бор хошуу хоорондын замын 113-р км 4-р зуутад суман шилжүүлэг шинээр тавих цонхны ажлыг заасан хугацаанд нь дуусгаж хөдөлгөөнд нээсэн. “Монголиан Транс Ложистик” ХХК-ийн албан тушаалтануудтай хамтран шинэ суман шилжүүлгийг хэрхэн ашиглах талаарх хамтарсан акт үйлдсэн.
- Өртөө зөрлөгийн галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой ажиллагсдын ажлын байранд үзлэг шалгалт хийж хатуу тооцоот багаж хэрэгсэл, шор баригч, түлхүүр зэргийн тоог гаргаж холбогдох инженер, мэргэжилтэнд мэдэгсэн.
- Өртөө зөрлөгүүдийн сумчин дохиочин нарт галт тэрэг угтан авах, үдэн гаргах технологит ажлын дараалал, холбогдох баримт бичгийн талаар сургалт орж, заавар зөвлөгөө өгсөн.
- Галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой хөтлөгдөж буй ширээний журнал, утсан телеграфын дэвтэр, өдөр тутмын зам сумын үзлэгийн дэвтэр, анхаарамжийн дэвтэр, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчын тушаалын дэвтэр, замын утсан мэдээний маягт, ташуу улаан зураастай бланк, анхаарамжийн маягт зэргийг хэрхэн хөтлөж байгаа эсэх дээр үзлэг хийж, шаардлага хангахгүй, алдаатай хөтлөлт зэрэг дээр тухай бүр нь зааж зөвлөж, арга зүйн зөвлөгөө өгсөн.
- Томилолтоор ажиллаж байх хугацаанд Гүйцэтгэх захирлын баталсан техникийн шалгалтыг газар дээр нь шаардлагатай 3 галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч, 1 өртөөний орлогч дарга, 4 зөрлөгийн жижүүр, 1 галт тэрэгний найруулагч, 1 туслах найруулагч нийт 10 ажилтнаас техникийн шалгалт авсан.
- Цогтцэций өртөөний ачилтын салбар замд сэлгээний ажил хийх түр зааврыг өртөөний орлогч даргатай хамтран боловсруулсан.
- Цогтцэций өртөөний нийт ажилчдад Хяналт шалгалтын газар, Өртөөний удирдах ажилтнуудтай хамтран “Хөдөлгөөнчдийн нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр тулгамдаж буй асуудлууд, Хувь хүний сахилга хариуцлага, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээ, гологдол зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зөвлөлдсөн.
- Гүйцэтгэх захирлын өгсөн үүргийн дагуу Хулангийн шанд, Бор хошуу, Хунхар заг, Баянбулаг, Ар хонгилдог, Хонхор толгой зөрлөгүүдийн технологийн амрах байр болон жижүүрийн байруудад үзлэг, шалгалтыг хийж шаардлагатай засвар үйлчилгээ, сэлбэг материалын жагсаалтыг нэгтгэн гаргасан.
- Архонгилдог зөрлөгөөс ачигдаж буй Оюутолгойн ууттай зэсийн баячмал ачих үеийн нөхцөл байдал, Ачилт хийх үеийн аюулгүй ажиллагаа, ачилтын техникийн нөхцлийн дагуу ачигдаж байгаа эсэх, ачааны бэхэлгээг технологийн дагуу бэхэлж байгаа эсэх дээр тогтмол хяналт тавьж газар дээр нь ажилласан.

- “УБТЗ”ХНН-ын вагоны аж ахуйн албаны комисстой Зүүнбаян өртөөн дээр ачааны вагоны солилцооны асуудал, автотоормос хэрхэн турших, вагон гэмтсэн тохиолдолд хэрхэн ажиллах, бууршгүй нөөцийн бүрдүүлэлт, галт тэрэг хүлээлгэн өгөх, хүлээн авах чиглэлээр хяналт тавьж ажилласан.
- Компанийн эзэмшлийн болон эзэмшлийн бус ачааны вагонуудад өвөл, зуны тээвэрт бэлтгэх үзлэг засварыг хийж, баталгаат мөрийн хэмжээнд хөдөлгөөний аюулгүй ажиллагааг бүрэн хангах зорилгоор “Ачааны вагоныг өвөл, зуны тээвэрлэлтэд бэлтгэх үзлэг, засварын журам”-ын дагуу Эрдэнэс Тавантолгойн төмөр замд ашиглагдаж байгаа 20 хоппер вагонд ТҮ-2 хийсэн ажилд хяналт тавьж ажилласан.
- 2022-04-21-нд Хулангийн шанд зөрлөгт хяналт шалгалтаар ажиллахдаа 588731, 587337 дугаарын вагоны автодэглэмийн тохируулга алдагдсан байсныг илрүүлж, холбогдох ажилтнуудад шаардлага тавьж засварлуулсан.
- Архонгилдог-Цогтцэций хооронд буюу 287,1-416,1 км-т зам хэмжигч вагоны хэмжилтээр замын дундаж балл 63 гарсан ба ТЗЗБМА-ын замчид замын III, IV-р зэргийн гэмтлийг засварлах ажлын гүйцэтгэлийг шалгаж ажилласан.
- Баянбулаг зөрлөгийн 2,3-р замд сум №3,5 тоонолжийн арын уулзварт төгсгөлийн боолт дутуу байсан зөрчлийн талаар салбар хариуцсан захирал, “УБТЗ”ХНН-ийн ПДМС-ын албан тушаалтан нартай холбогдон шаардлага тавьж засуулах арга хэмжээг авсан ба зассан талаарх актыг авч ажилласан.
- ЗТХЯ-ны 2022 оны 04 дүгээр сарын 06-ний өдрийн 38-07-077-/013 тоот удирдамжийн дагуу ЗТХЯ-ны ХШҮДАГ-ын улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй хамтран 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 15-ны хооронд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажил, тээвэрлэлтийн үйл ажиллагаа, MNS 6229:2021 стандарт, батлагдсан зураг төсөл, техникийн шаардлагуудыг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж ажилласан.
- ЗТХЯ-ний №038-07-074/011 шаардлагын 16-р зүйлд заасан ус зайлуулах хоолойнуудын элсийг цэвэрлэх, Баянбулаг, Хонгор толгой зөрлөгүүдийн тэгш талын бэлчир, гол замын 312 км-т төмөр замын гармын шалавч тавигдаагүй 3 гармын шалавч тавих ажлыг “УБТЗ”ХНН-т шаардлага тавьж хийж гүйцэтгүүлсэн.

## 2. Ажлын төлөвлөлт, биелэлтийн чиглэлээр:

Хяналт шалгалтын газраас 2022 онд хийж хэрэгжүүлэх 88 заалттай нэгдсэн ажлын төлөвлөгөө гарган гүйцэтгэлийг тухай бүрд нь хэрэгжүүлж ажиллаж байгаа ба Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр газрын хэмжээнд сар бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллаж байна.

Жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийн хувь



### 3. Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр боловсруулсан тушаал, дүрэм, журмууд:

Компанийн хэмжээнд хэрэгжүүлэх Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох заавар, журмуудыг боловсруулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын зүгшрүүлэлтийн тээвэрлэлтэй холбоотой мөрдөх түр дүрэм, журмууд болон техникийн бичиг баримтын боловсруулалтан дээр хяналт тавьж шаардлагатай заавар зөвлөмжүүдийг тухай бүрд нь өгч ажиллаж байна.

№	Тушаал		
	№	Огноо	Агуулга
1	A/19	2022.02.10.	Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагаанд гарсан дутагдлыг судлан бүртгэх журам
2	A/29	2022.02.18.	Анхаарамж тогтоох ба өөрчлөх, захиалга өгөх зэргийг шуурхай дамжуулах журам
3	A/72	2022.04.08.	Сүйрэл, осол, гологдлыг ангилан бүртгэх, шинжлэн судлах дотоод журам.
4	A/92	2022.05.02.	Байцаагчийн заалтын дэвтэр хөтлөх журам
5	A/93	2022.05.02.	"Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой машинч, туслах машинч болон бусад ажилтнуудад эмчийн үзлэг хийх тухай журам" "Эмчийн үзлэгт хэрэглэгдэх багаж хэрэгсэл, эм тарианы жагсаалт, хөтлөгдөх бичиг баримт, түүний загвар", "МТЗ" ТӨХК-ийн ажилтнуудын согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгаж тогтоох журам" "Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой машинч, туслах машинч болон бусад ажилтнуудад эмчийн үзлэгийг тусгай хувиараар хийх журам"
6	A/100	2022.05.19.	"Хөдөлмөр хамгааллын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангамжийн ажлыг зохион байгуулах, хяналт тавих журам
7	A/132	2022.09.15.	"Анхаарамж олгох түр журам"

### 4. Галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой ажилчдын техник мэргэжлийн сургалт, шалгалтын чиглэлээр:

Компанийн хөдөлгөөнтэй холбоотой ажилчдаас техникийн мэдлэгийн шалгалт авах журмыг шинэчлэн боловсруулж, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн шинэ төмөр зам дээр ажиллах нийт 95 ажилтанд нэгдсэн журмаар Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмүүдээр болон мэргэжлийн чиглэлээр 14 хоногийн хугацаанд 11 сэдвээр техникийн сургалтыг зохион байгуулж мэдлэгийг бататган техникийн шалгалт авч ажилласан. Цаашид шинээр ажилд орж буй ажилчидаас тухай бүрд нь сургалт хийж шалгалт авч ажиллаж байна.

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын  
2021 оны 11 дугаар сарын 07-ны өдрийн  
132 дугаар үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн  
1. 2.

ТЕХНИКИЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Наг. Ерөнхий зүйл:

1.1 Энэхүү журмын зорилго нь үйлдвэрлэлийн үр ашиг, чанар, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, ажилтанд тодорхой нэрийн мэргэжлийн мэдлэг, үр чадвар, зөв хандлагыг дээшлүүлэх, баталгах, галт тэрэгний хөдөлгөөнийг аюулгүй байдалтай хангаж ажиллахаас гадна, шинэ агуу ажлын үүрэг, даалгавар, төрүүлэх зэргийн ажиллах хүний нөөцийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажилтны өсөн дэвжих мэдлэг чадварыг дээшлүүлэх, баталгах, нэмэгдүүлэх боломжийг олгоход оршино.

1.2 "Монголын төмөр зам" ТӨХК-ийн газар, алба, нэгжүүдэд техникийн сургалт зохион байгуулах арга хэлбэр, дэс дараалал, аргачлалыг энэхүү журмаар тогтооно.

1.3 Энэхүү журамд мэргэжлийн бонусын хүчин бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн үрэг, давтан сургалт болон бусад төрлийн хүний нөөц бэлтгэх сургалт хэмээрхгүй болно.

Хоёр. Чиглэл:

2.1. Төмөр замын мэргэжлийн ажилтны тэрсэлтгүй сургалтын тогтолцооны үндэс нь үйлдвэрлэлийн нөхцөлд сургаж, дадлагажуулах техникийн сургалт юм. Дараахид "техникийн сургалт" гэж

Гурав. Сургалтын зохион байгуулалт:

3.1. Харьлалх газар, алба, нэгжийн нийтлэг үүрэг:

3.1.1 Үйлдвэрлэл дээр төхөөрөмжийн сургалт явуулахад арга зүйн зөвлөмж өгөх, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангана.

3.1.2 Техникийн кабинет, зааварчилгааны ерөө, бусад тоохикийн хэрэгслийн бүртгэл жагсаалтыг гарган, тэдгээрийг ажиллуулах талаар зөвлөмж гаргаж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

3.1.3 Газар, алба, нэгжийн хичээл зөвхөн буй инженер, техникийн ажилтан, өртөөний дарга, орлогч дарга, зохион байгуулалтын үйлдвэрлэлийн газрын хөдөлгөөн, зааварлагч машинист, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн нар нь сургалтын төлөвлөгөөг боловсруулж харьяалах албадын даргаар батлуулна.

3.1.4 Техникийн хичээлийн явцыг холбогдох газар, албадын удирдах болон инженер техникийн ажилтан, түүнийг үр дүнтэй явуулах, боловсруулж болгох талаар заавар, зөвлөмж, чиглэл өгнө.

3.1.5 Үзүүлэлт, гарын авлага, хичээл зэргийг техникийн сургалтад зориулан бэлтгэх ажлыг зохион байгуулна.

3.1.6 Сургалтыг зохион байгуулах арга, хэлбэрийг орчин үеийн шинэ довшилтат технологийг уялдуулах, суралцагчдын ирээдэй санаачилгыг өрнүүлэх, шинэлэг аргыг байнга аралхийлж, нэвтрүүлэх чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжүүлж ажиллана.

3.1.7 Өөрийн харьяалах алба, нэгж бүр нь шалгалтын комиссыг байгуулж шинэ ажилтнаас шалгалт авч зохих үнэлгээг өгнө.

3.1.8 Компанийн хэмжээнд шинэ техник, технологийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахдаа мэргэжлийн ажилтнуудыг сургах асуудлыг хамтад нь шийдвэрлэх лэрээ

Шалгалтын үндсэн хуудас

№	Ажилчдын нэр	Албан тушаал	Шалгалтын дүн	Шалгалт өгсөн ажилтны гарын үсэг
1	Ц. САРАНТУЯА	ДС	76%	Сарантуяа
2	С. ГУЛЬСЫН	ДС	70%	Гульсын
3	З. МОНХ-ЭРДЭНЭ	ДС	66%	Монх-Эрдэнэ
4	Г. БАЯСГАМАН	ДС	76%	Баясгаман
5	Э. СОЛОНГО	ДСП	82%	Солонго
6	О. АЛТАНХУЯГ	ДСП	76%	Алтанхуяг
7	О. АМАРЖАРГАЛ	ДСП	74%	Амаржаргал
8	О. ХУЛАН	ДСП	76%	Хулан
9	Б. ЭРХЭМБЯАР	ДСП	66%	Эрхэмбаяр
10	Б. ЭНХМАА	ДСП	72%	Энхмаа
11	Д. ШИНЭТУЯА	ДСП	64%	Шинэтуяа
12	О. БАТ-ОНИ	Сум/дох	90%	Бат-Они
13	З. ЧИНЛҮРЭВ	Сум/дох	78%	Чинлүрэв
14	Г. БАЗАР	Сум/дох	66%	Базар
15	Ж. ЖАМЪЯНПҮРЭВ	Сум/дох	60%	Жамъянпүрэв
16	Н. УРЖИХАНД	Сум/дох	66%	Уржиханд
17	Д. ДАВМДАВА	АСДП	64%	Давмдава
18	Д. ДЭВГЭРЦОГТ	Сум/дох	46%	Дэвгэрцогт
19	Б. БАТЖАНЦАН	Сум/дох	56%	Батжанцан
20	О. БАТХУУ	Сум/дох	64%	Батхуу
21	О. ОРГОНСЭМЭНГЭ	Сум/дох	54%	Оргонсэмэнгэ
22	Б. НАМАЛ	Сум/дох	68%	Намал
23	Э. ТҮМЭНЧИЛЭН	Сум/дох	76%	Түмэнчилэн
24	Э. МОНХБОЛД	ДСД	54%	Монхболд
25	С. ДЭГДЭРМОН	ДС	72%	Дэгдэрмон
26	Х. ГАНХУРАГ	Сум/дох	66%	Ганхураг
27	О. МОНХБЭР	ДСД	60%	Монхбэр
28	М. ЭНХМӨГӨӨ	ДСД	62%	Энхмөгөө
29	П. ХОЛМОГ	ДСД	78%	Холмог
30	П. МОНХ-ЭРДЭНЭ	ДСД	78%	Монх-Эрдэнэ

Комиссын бүрэлдүүн:

5. Байгаль орчны чиглэлээр:

2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар байгаль орчны чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замын Зүүнбаян өртөөнөөс гол шугамын 129 дүгээр км хүртэлх хиймэл байгууламж болон дээд, доод бүтцийг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд урьдчилсан дүгнэлт гаргах Техникийн комиссын бүрэлдэхүүн төслийн талбай дээр 2022 оны 01 дүгээр сарын 10-13-ны өдрүүдэд ажилласан бөгөөд энэ үеэр комиссын бүрэлдэхүүнд шаардлагатай баримт бичиг, нөхөн сэргээлтийн ажлын актууд, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай болон мал, амьтны гарцыг газар дээр нь танилцуулахаар төслийн талбай дээр ажиллав.
- Техникийн комиссын үзлэгээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэх зөвлөмж өгсний дагуу зохих арга хэмжээг авч ажиллаж байгаа ба 13 карьерийн нөхөн сэргээлтийн ажил хийж орон нутагт хүлээлгэж өгөхөөс 11 карьерийн нөхөн сэргээлт бүрэн дууссан, орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэж өгөхөөр хүсэлт өгөөд байна.
- Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.4-т заасны дагуу газар эзэмшигч нь газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэх ба энэ нь 5 жилд нэг удаа, эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэгдэг. Манай компанийн эзэмшилд байдаг 9 газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа сүүлийн 5 жилд хийгдээгүй бөгөөд 2021 онд хийлгэхээр төлөвлөсөн боловч төсөв, санхүүгийн улмаас хойшлогдож энэ онд хийгдэхээр болсон. Улмаар ажлыг хийлгэхээр Гүйцэтгэх захиралд танилцуулан зөвшөөрөл авч төсөл, сонгон шалгаруулалт хийлгэхээр холбогдох газарт шилжүүлээд байна. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа нь дараах газруудад хийгдэнэ.

	Байршил	Газрын хэмжээ	Эзэмших зориулалт
1	Багахангай дүүрэг	30 га	Аж ахуй (Засварын төв)
2	Дорноговь, Замын-Үүд	31.18 га	Шилжүүлэн ачих талбай
3	Дорноговь, Замын-Үүд	50 га	Холимог тээврийн ачааны терминал, ложистик төв
4	Дорноговь, Сайншанд	43 га	Үйлдвэрийн албан контор
5	Сэлэнгэ, Хүдэр	77.01 га	Төмөр замын зурвас газар, өртөөний барилга
6	Сэлэнгэ, Ерөө	24.3 га	Төмөр замын зурвас газар

7	Сэлэнгэ, Хүдэр	2 га	Ажилчдын орон сууц
8	Сэлэнгэ, Хүдэр	1.4 га	Дэд станц
9	Сэлэнгэ, Хүдэр	13.97 га	Шилэн кабель

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих.

- Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулахаар 01/498 дугаар албан бичгээр БОАЖЯ-нд хүргүүлээд байна. Тухайн оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд заагдсан хугацаанд хэрэгжиж байгаа эсэхэд тухай бүр хяналт тавин ажиллаж байна.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд Цогтцэций өртөө болон бусад 6 зөрлөгийн унд ахуйн худгуудыг гадны механик нөлөөлөл, хог хаягдал хуримтлагдахаас сэргийлэх үүднээс хамгаалалтын бүс тогтоож хашаажуулав.



- Өртөө, зөрлөгүүдийн хэмжээнд өдөр тутам хоол, хүнсний хаягдал ихээр гарч байна. Энэ нь хог хаягдлын хэмжээг ихэсгэх, ялзарч муудсанаас эрүүл ахуйн хэвийн нөхцөл алдагдах зэрэг сөрөг нөлөөлөлийг үзүүлдэг. Нөгөө талаар органик гаралтай хаягдал учраас задалж ялзмагжуулан байгальд шингээх, бордоо болгох боломжтой нь давуу талтай байдаг. Иймд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл дээр органик хаягдлыг ашиглан компост бордоо хийх боломжийг бүрдүүлэх талаар судалж, худалдан авах шаардлагатай хэрэгслийн судалгааг хийн Гүйцэтгэх захиралд танилцуулан зөвшөөрөл авч, нарийвчилсан төсвийг гаргуулахаар СЭЗГ-т шилжүүлээд байна. Органик хаягдлаар компост бордоо хийх нь дараах аргачлалын дагуу явагдах ба шаардлагатай бараа материалын худалдан авалтыг хийсний дараагаар тогооч, үйлчлэгч нарт сургалтаар практик дадлага олгоно.

### Бокаши хүнсний үлдэгдэл ялзмагжуулах сав ХЭРЭГЛЭХ ЗААВАР



**Алхам 1**  
Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдлийг жижиглэж бэлтгэнэ. Жижиглэснээр задрах, бордоошиж явцыг түргэсгэж өгдөг.



**Алхам 2**  
Саван дотроо шүүрүүлэх тавиурыг хийгээд хүнсний үлдэгдлийн эхний үеийг ниймгэн зулж дэвсээд ашигтай бактерийн уусмал шүршинэ.



**Алхам 3**  
Уусмалаар шүршсэний дараа шахах таглаагаар сайтар шахаж доош суулгана. Саванд бие үлдэгдэл байгаа бол шахдаг тагийг байнга таглаатай байлгана.



**Алхам 4**  
Исч ялзмагжих явцад савны ёроолд шигшгэн хуримтлагдах ба энэ нь ургамалд маш сайн бордоо болдог. Шингэснийг юүлж аваад буцаад хавхлагыг хаана.



**Алхам 5**  
Савны тагийг аль болох олон дахин онгойлгохгүй байх хэрэгтэй. Сав бүрэн дүүрмэгц тагийг хааж тасалгааны хэмд 2 долоо хоног байлгана. Исч ялзмагжих явцад хий үүсч, үнэр гарч болох ба үнэрийг гадагшлуулахын тулд таглааг бага зэрэг онгойлгоод хий гарсны дараа тагийг заавал буцааж хаагаарай.

Төмөртэй өртөөний байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх

Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр сумдын нутаг дэвсгэрт байрлах Төмөртэй өртөөний байгаль орчны нөлөөлөлийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2014 онд батлуулсан. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай

хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөлөлийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасан байдаг. Түүнчлэн Засгийн газрын 2013 оны 374 дүгээр хавсралтаар баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.12-т зааснаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь 5 жилээс дээшгүй хугацаатай байх бөгөөд түүнээс олон жил үргэлжлэх төслийн хувьд менежментийн төлөвлөгөөг 5 жил тутамд шинэчлэн боловсруулж батлуулахаар зохицуулсан байдаг тул байгаль орчны нөлөөлөлийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх хэрэгцээ шаардлага үүссэн. Иймд байгаль орчны нөлөөлөлийн үнэлгээний ажлын даалгаврыг гүйцэтгэх захирлаар батлуулж, байгаль орчны үнэлгээний “Дээшлэх говь” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна.

- Нэмэлт тодотголын хүрээнд БОАЖЯ-наас 2022 оны 13/4668 дугаар ерөнхий үнэлгээний дүгнэлт гарсан бөгөөд үүний хүрээнд байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажил холбогдох аргачлал, журмын дагуу хийгдэж байгаа ба гүйцэтгэгч байгууллагаас нарийвчилсан үнэлгээний тайлангийн төслийг эцэслэж ирүүлээд байна.

Төмөртэй өртөөний гүний худаг тоолуур суурилуулах

- Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-т заасны дагуу ус ашиглагч нь ус авах цэг, газрын доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах үүрэгтэй байдаг. Нөгөө талаас усны эх үүсвэрт тоолуур суурилуулах нь ус ашиглалт, хэрэглээг бодитоор тодорхойлох ач холбогдолтой. Төмөртэй өртөөнд өртөөний барилга болон ажилчдын орон сууцны 2 гүний худаг байх бөгөөд тоолуургүй байсан тул D40 маркийн хоёр тоолуур худалдан авч суурилуулсан.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд

- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй төслүүдийг хамруулан ирэх 10 жилд буюу 2022-2032 он хүртэлх хугацаанд тарьж ургуулах мод, бутны график төлөвлөгөөг гаргаж Гүйцэтгэх захирлаар батлуулав.
- “Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжих “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө, хуваарийг гарган Гүйцэтгэх захирлаар батлуулан ажиллаж байна.
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талбайд 1000 ш, 05 дугаар сарын 20-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг Бумбатын рашаанд 50 ш, 10 дугаар сарын 14-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг “Инчон мөрөөдлийн төгөл” төслийн талбайд 150 ш мод тарьж суулгасан.

Байгаль орчны сургалтад хамрагдах

- БОАЖЯ, “Монголын байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо” ТББ-аас зохион байгуулсан байгаль орчны мэргэжилтнүүдийг чадавхжуулах шаталсан сургалтын хүрээнд “Агаар бохирдуулах бодисын хаягдлын тооллого хийх аргачлалын хэрэглээ”, “Биологийн олон янз байдал, түүний хамгааллын төлөвлөлт” сургалтад тус тус хамрагдав.
- “Байгаль орчны менежментийн тогтолцоо-Шаардлага, ашиглах заавар” MNS ISO 14001:2016 стандартыг нэвтрүүлэх хүрээнд стандартын сургалтад 7 хоног бүр хамрагдаж компанийн хэмжээнд баримтлах байгаль орчны бодлого, зорилтуудыг тодорхойлох, гадаад, дотоод орчны (SWOT) шинжилгээ хийх, сонирхогч талууд ба тэдгээрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийн үнэлгээ хийх, эрсдэл боломжид суурилсан төлөвлөгөө боловсруулах, байгаль орчны процессуудыг тодорхойлох, процессийн зураглал хийх, эрсдэл, нөлөөллийн үнэлгээ хийх, хог хаягдлын журмын төсөл боловсруулах ажлуудыг гүйцэтгээд байна.

Хог хаягдлын тайлан хүргүүлэх

- “Төлөвлөгөө батлах тухай” Зам, тээврийн сайдын 2016 оны 174 дүгээр тушаалаар баталсан Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг улирал тус бүрээр гаргаж Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлж байна.

Баруун, зүүн чиглэлийн төмөр замын төслийн ТЭЗҮ боловсруулах

- Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан Нарийн сухайт – Шивээхүрэн чиглэлийн төмөр замын төслийн Шивээхүрэн хилийн боомт, баруун чиглэлийн Арцсуурь – Нарийн сухайт – Шивээхүрэн, зүүн чиглэлийн Хөөт – Бичигт, Хөөт – Чойбалсан чиглэлийн төмөр замын төслийн ТЭЗҮ боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, ТЭЗҮ-д байгаль орчны чиглэлээр тусгагдах ажлуудыг боловсруулан

## **ТӨСЛИЙН НЭГЖ:**

### **“Тавантолгой - Зүүнбаян” чиглэлийн төмөр зам**

2022 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн ямаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаж Ар хонгилдог зөрлөгөөс Зүүнбаян өртөө хооронд техникийн комисс ажиллаж төмөр замыг төслийн түвшинд хүрснийг дүгнэлтээр баталгаажуулан ажилласан. Тус ажлын хэсэгт хариуцсан чиглэлийн дагуу инженерүүд төслийн баримт бичгийн бүрдэл, хянан баталгаажуулсан акт, техникийн шаардлага, ил далд ажлын акт, ажлын зураг, ажлын даалгавар зэрэг материалуудыг бэлдэж танилцуулсан. Ажлын хэсгийн зөвлөмжөөр гарсан шийдвэрийн дагуу улсын комисс ажиллахтай холбоотойгоор бусад шаардлагатай баримт материалыг бүрдүүлэн ажилласан байна.

Цогтцэций-Зүүнбаян чиглэлд галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулахтай холбоотойгоор бэлтгэл ажлын хүрээнд гаалийн ачилт буулгалтын талбайн барилга угсралтын ажил дээр хяналт тавин ажиллаж байна. Үүнд: ачилтын талбайн салбар зам, ачилтын талбай барилгын ажил, депо, засварын цехийн барилгын ажил зэрэг ажлуудад чиглэл чиглэлийн инженерүүд хяналт тавин ажилласан байна.

Баруун чиглэлийн төмөр зам Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Зүүн чиглэлийн төмөр зам Хөөт-Бичигт-Хөөт-Чойбалсан чиглэлийн төслүүдийн урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хэсэгт холбогдох инженерүүд орж судалгааны ажлыг эхлүүлэн ажилласан байна.

2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн ямаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаж Цогтцэций өртөөнөөс Ар хонгилдог зөрлөг хооронд техникийн комисс ажиллаж төмөр замыг төслийн түвшинд хүрснийг дүгнэлтээр баталгаажуулсан. Мөн техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлэх чиглэл өгч ажилласан.

2022 оны 10 дугаар сарын 21-28-ны өдрийн хооронд Эрчим хүчний төрийн нарийн бичгийн даргын А/145 дугаартай тушаалаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуух эрчим хүчний барилга угсралтын ажил дууссантай холбогдуулан техникийн комисс ажиллаж Цагаансуварга дэд станцын 22/35 кВ-ын өргөтгөл, 343.2 км 35 кВ-ын хоёр хэлхээт ЦДАШ, 35/0,4 кВ-ын 2\*160 кВА чадалтай 6 зөрлөгийн дэд станцуудыг байнгын ашиглалтад оруулсан.

### **Гүйцэтгэлийн тайлан мэдээ хянах**

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн барилга угсралтын ажилбар бүрийн явц мэдээ, тайланг хүлээн авч, холбогдох инженерүүд хянан ажиллаж байна. Төмөр замын төслийн хэрэгжилтэд хяналт тавих тухай Гүйцэтгэх захирлын 2020 оны 02-р сарын 17-ны өдрийн А/19 тоот тушаалын дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд хийгдэж байгаа Зөвлөх болон Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг хүлээн авч холбогдох Хяналтын багуудаар хянуулж "Тайлан хянан баталгаажуулсан тухай" акт үйлдэн ажилласан байна.

### **Гаалийн хяналтын талбайн доод бүтцийн барилга угсралтын ажлын явц**

- Карьерын хайгуул хийж баталгаажуулсан
- Улаан шугам хүлээлцэж, газрын гадаргын түвшин шалгасан
- Ажлын тоо хэмжээ шалгаж, баталгаажуулсан
- Ухмал байгуулан, суурийн үе байгуулан захиалагчийн хяналтыг гүйцэтгэн ажилласан.

### **Гаалийн хяналтын талбайн дээд бүтцийн барилга угсралтын ажлын явц**

- Ачилтын талбайг гаалийн хяналтын талбайд нийцүүлэн дагтаршуулан бэлтгэсэн
- Талбайн хашааны бетон суурийн ажил явагдаж байна

- Гадна торон хашаа хийгдсэн
- Балласт тээвэрлэх ажил хийгдсэн
- Гаалийн хяналтын ачилт, буулгалтын талбайн барилга угсралтын ажилд геодези, замын, материалын инженерүүд хамтран хяналт тавин ажилласан.

### Мал амьтнаас хамгаалах хориг хашааны барилга угсралтын ажлын явц

Хориг хашааны барилга угсралтын ажлыг ХХЕГ-ын 0119-р анги хийж гүйцэтгэхээр гэрээ хийж 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр төслийн талбайд ажилласан. Тухайн ажлын явцыг материалын инженер, тоо хэмжээний инженер тус тус хянаж гүйцэтгэлийн тайланг газар дээр нь баталгаажуулан удирдах албан тушаалтанд танилцуулсан. Сүлжмэл торон хашаа 12485м гүйцэтгэл-32.51%, сүлжмэл тортой хориг хашаа 13774м гүйцэтгэл 34.65%, хориг хашаа 15695м гүйцэтгэл 28.67% байна. Төмөр шон 8454 ш ирсэн өртөө, зөрлгүүдэд тараагдаж байна. Үлдсэн төмөр шон гаалиас татан авалт хийгдэж байна.

### Кемпийн үйл ажиллагааны хүрээнд хийсэн ажил

- Кемпүүдийн дотоод зохион байгуулалт буюу ажиллагсдын амрах байр, оффис, угаалга, ариун цэврийн өрөөний хуваарилалтыг зөв зохистой, хүрэлцээтэй зохион байгуулах чиглэлийг кемпийн админ бүрт өгөх, хяналт тавин ажилласан
- Кемпүүдийн хүнс, угаалгын зориулалттай ашиглах усан хангамж, генератор, автомашинд шаардлагатай түлшний хэрэгцээ шаардлагыг хангаж ажилласан
- Кемпийн дотоод үйл ажиллагааны хүрээнд хоолны бүртгэл, түлшний бүртгэл, автомашины замын хуудас, үйлчилгээний ажиллагсдын бүртгэл гэх мэт бүртгэлийг хөтлөн ажилласан
- Кемпийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, нэгдсэн тоо, тооллого зохион байгуулсан.

### Төслийн баримт бичиг боловсруулах ажлын явц

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн баримт бичгийг цэгцлэх, боловсруулах ажлыг чиглэл чиглэлээр хариуцсан инженер, бичиг хэргийн ажилтан архивт хүлээлгэн өгөхөөр Архивын ерөнхий газар болон байгууллагын архивын ажилтантай хамтран арга зүйн чиглэл авч ажилласан байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн ажлын даалгавар, техникийн шаардлагын баримт бичиг дээр дахин боловсруулалт хийн дараагийн төсөл, судалгааны ажилд шаардлагатай арга зүйг судлан ажилласан.

### Доод, дээд бүтцийн барилга угсралтын ажил

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын гүйцэтгэл
1	Газар шорооны ажил	м3	100%
2	Хоолойн ажил	ш	100%
3	Гүүрийн ажил	ш	100%
4	Өртөө, зөрлөгийн барилгын угсралтын ажил	ш	100%
5	Эрчим хүчний барилга угсралтын ажил	ком	98.6%
6	Дохиолол, холбооны ажил	ком	98.5%
7	Шилэн кабелийн ажил	км	99.8%
8	Буталмал чулуу үйлдвэрлэл	м3	99%
9	Төмөр бетон дэр үйлдвэрлэл	ш	100%
10	Дээд бүтцийн үе угсрах ажил	км	100%

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

2022-12-09